



“Газрын тос” клуб



Газрын тосны инженерийн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын суралцах болон нийгмийн идэвхийг дээшлүүлэх, мэргэжлийн хүрээний мэдээ, мэдээлэлээр хангах, оюутнуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор 2005 оны 3-р сард “Газрын тос” клуб байгуулагдсан ба 2009 оноос үйл ажиллагаагаа идэхитэй явуулж эхэлсэн билээ. “Газрын тос” клубын зөвлөх багшаар В.Алимаа ажилласан.



Клубын үүсгэн байгуулагчид ба анхны гишүүд. 2009 он

(Газрын тосны хадгалалт тээвэрлэлт мэргэжлийн ангийн 2-р дамжааны оюутан Б.Тэнгэрцэцэг, 3-р дамжааны З.Солонго, зөвлөх багш дэд проф, док(Ph.D) В.Алимаа, Газрын тосны өрөмдлөг мэргэжлийн 2-р дамжааны оюутан О.Лхамаа, Газрын тосны барилга байгууламжийн 3-р дамжааны оюутан Гантуяа (урд эгнээнд), Газрын тосны барилга байгууламжийн 2-р дамжааны оюутан О. Мөнхсүх, Газрын тосны хадгалалт тээвэрлэлт мэргэжлийн 2-р дамжааны оюутан З.Галсан, Хий дамжуулалт хангамж мэргэжлийн 2-р дамжааны оюутан Б.Хархүү, Газрын тосны хадгалалт тээвэрлэлт мэргэжлийн 2-р дамжааны оюутан Г.Лхамдулам, З.Анухатан, Г.Солонго, Б.Сүндэръяа, Б.Чулуунтулга, Б.Баясгалан)

“Газрын тос” клуб нь байгуулагдсан цагаасаа эхлэн Газрын тосны мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулж, үр бүтээлтэй ажиллаж ирсэн. Тухайлбал:

- Жил бүр газрын тосны чиглэлээр баклаврын шатанд суралцаж байгаа оюутнуудын ЭШ-ний хурлын “Монторх” ХХК-тай хамтран зохион байгуулж ирсэн.



Оюутны эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцсон оюутнууд. 2009 он

Оюутан Ж.Эрхэмбаяр нь Монгол Улсын анхны ерөнхийлөгч П.Очирбатын нэрэмжит ШУТИС-ийн “Оюутны эрдмийн IX их чуулган” –д амжилттай оролцож шагналт байранд шалгарсан болно.



Оюутны эрдэм шинжилгээний хуралд оролцогсад “Монторх” ХХК-ий захирал док (Ph.D) Л.Оросо болон багш нарын хамт



“Газрын тос” клуб нь оюутны зөвлөлтэй хамтран ажилладаг ба сургуулиас болон оюутны зөвлөлөөс зохион байгуулдаг үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог.

- Газрын тосны салбарын ахмад эрдэмтэд, Монгол улсын зөвлөх инженерүүдээр лекц уншуулдаг.



Газрын тосны салбарын ахмад эрдэмтэдтэй Газрын тосны өрөмдлөг, олборлолт, хадгалалт тээвэрлэлт, байгууламж, Хийн хангамж дамжуулалт мэргэжлийн бакалаврын зэргийн шатанд суралцаж байгаа оюутнууд оролцсон. Уг уулзалт ярилцлагад доктор профессор Ж.Цэвээнжав “Газрын тосны салбарын сургалт, судалгааны асуудлууд”, доктор П.Санж “Газрын тосны цооногийн судалгаа туршилт “доктор Ц.Багмид “Газрын тосны олон улсын худалдаа”, Нефть хий ассоциацийн тэргүүн Л.Норовринчин “Нефть хий” ассоциацийн үйл ажиллагаа” Амбер ХХК-ийн зөвлөх Д.Амгалан “Шатахуун, түлшний техникийн шаардлага, чанар”, ЭмПиАй консталинг ХХК-ий захирал Д.Гансүх – Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн тоног төхөөрөмжүүд, хэтийн төлөв байдал” зэрэг сонирхолтой илтгэл тавьсан ба оюутнууд сонирхсон асуултандаа хариулт авлаа.



Газрын тосны боловсруулалт сэдвээр Монгол улсын газрын тосны анхны инженер, хүндэт профессор, док(Ph.D) Ц.Багмид лекц уншив. 2015 он